

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ
Үндсэн зорилго, зорилт

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ын үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх
2. БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

Хамрах хүрээ

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

1. Төслийн хүрээнд бий болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох зардлыг тооцох;
2. Нөхөн сэргээх, нөхөн хамгаалах ажлыг төлөвлөж, зардлыг тооцох;
3. Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох;
4. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
5. Нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулах зэрэг асуудлыг тусгана.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарчим

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг менежментийн бодлогоор хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаагаа журамлах үүднээс байгууллагын дотоод журам, дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол Улсад мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцсэн байхаар боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөнө.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрийг төсөл хэрэгжүүлэгч хүлээх хуулийн зохицуулалт бий.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, төсөв

БОМТ нь төслийн хэрэгжилтийн хугацаанд бүрэн хэрэгжинэ. Үүнд:

- Төслийн эхний жилд төсөл хэрэгжүүлэгч хүрээлэн буй орчныг бохирдуулахаас сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангуулахад голлон анхаарна. Энэ шатанд төслийн хүрээнд үүсэх нийт сөрөг нөлөөллийн үзүүлэлтийн байвал зохих норм, стандартыг мөрдөж ажиллана. 2 дахь жилээс уурхайн тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, эхний жилийн биелэлтийн тайлангийн хамт байгаль орчны төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн батлуулна.
- Төслийг хаасны дараа нөхөн сэргээлтийн чанар, үр дүнд хяналт тавьж, мониторинг хийнэ. Шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийж нэмэлтээр ургамалжуулах бөгөөд цаашид нөхөн сэргээлтийн үр дүнг орон нутагт хүлээлгэн өгнө.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ					
- Ил уурхайн хөрс хуулалт, тэсэлгээ, нүүрс олборлох, ачиж буулгах, тээвэрлэх үйл явц, машин техникийн хөдөлгөөнөөс тоос тоосонцор ихээр үүсэж агаар орчныг бохирдуулах	Элэгдэл, эвдрэлд орсон талбай, уурхайн дотоод зам дагуу усалгаа хийх, автомашины хурдыг хязгаарлах	Үйл ажиллагааны зардал		4-9 сард өдөр жил бүр	- MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
- Салхи ихтэй үед элэгдэл, эвдрэлд орсон газруудаас сул шороо хийсч тоос дэгдэх	Лицензийн талбайд тохиромжтой байршил сонгон тарьц суулгац тарьж ургуулах	Нөхөн сэргээлтийн зардалд тусгав.		Жил бүр	- MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.
	Жил тутам агаарын бохирдол үүсгэгч хорт хий, тоосжилтын хэмжилт хийлгэж, мэдээллийн сан үүсгэх	ОХШХ-т тусгагдсан.		Жил бүр	Техникийн ерөнхий шаардлага.
	Нүүрс тээвэрлэлтийн замыг хатуу хучилттай болгох	Үйл ажиллагааны зардал		2018-2019 он	
Халаалтын зуух, хүнд даацын машин техник, уурхайн ажилчдын хэрэгцээнд ашиглаж буй автомашины хөдөлгүүрээс ялгарах хорт хий агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Үйл ажиллагааны зардал		Тухай бүр	- Агаарын тухай хууль. 21.1, 29.1
	Агаарын бохирдлын төлбөрийг тогтоосон хугацаанд төлж байх	Үйл ажиллагааны зардал		Жил бүр	- Агаарын бохирдлын тухай хууль. 4.1, 5.1, 6.1.1, 6.1.3, 6.1.4, 7.1, 7.3, 7.4, 9.1, 9.1.3, 9.1.4
	Жил тутам агаарын бохирдол үүсгэгч хорт хий, тоосжилтын хэмжилт хийлгэж, мэдээллийн сан үүсгэх	ОХШХ-т тусгагдсан.		Жил бүр	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 21.3
Ахуйн хог хаягдлыг зориулалтын бус талбайд, ил задгай удаан хадгалснаасорчин бохирдох, таагүй үнэр гарч болзошгүй	Ахуйн хог хаягдлыг богино хугацаанд зайлуулж, хог хаягдлын болон бохирын цэгт тогтмол хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	300.0	1.5	Сар бүр	- БОНБУ тухай хууль
	Хог хаягдлыг ил задгай шатаахгүй байх	-			- Хог хаягдлын тухай хууль. 10.2, 10.3

Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ					
Усны нөөцийг зөвшөөрөлгүй ашиглах, усыг их хэмжээгээр ашигласнаас усны нөөцөд нөлөөлж болзошгүй.	Уурхайгаас шавхан зайлуулж буй усыг задгайлан урсгахгүй байх, тусгай цэвэршүүлэх далан, тунгаагуурт хуримтлуулах	200.0	2.4	2021-2025	<ul style="list-style-type: none"> - MNS 3342:1982 Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага. - MNS 0899:1992 Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх бүлгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага - MNS 6148:2010 Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ - MNS 0900:2010 Ундны усны чанарын стандарт - MNS 4943:2000 Усны чанар. Хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага. - Усны тухай хууль. 24-29 зүйл - БОНБУ тухай хувьл - Усны бохирдлоос хамгаалах журам (БО.ЭМ-ийн сайдын 1997 оны хамтарсан 143/352 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт) - Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам (БОНХ-ийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалын хавсралт)
	Уурхайгаас зайлуулах усны найрлага, тоохэмжээнд хяналт, ажиглалт явуулж, усанд байх умбуур бодис, перманганатын исэлдэх Жилд 2 удаа ОХШХ -г тусгасан 2021 -2025 чанар, төмөр, азот аммони, кадми зэрэг бохирдлын үзүүлэлтээр мониторинг хийх	300	1.5	2021-2025	
	Уурхайн ашиглалтын явцад аадар, хур борооны үерээс үүсэх урсац ухаш руу оруулахгүй байх үүднээс үерийн байууламжийн зураг төслийг тусгайлан	2.0	2.0	2021	
	Уурхайн суурингаас гарах ахуйн бохир усыг халдваргүйжүүлэх, саармагжуулах био - исэлдэлтийн байгууламж байгуулах	2.5	2.5	2021	
	Ус ашиглах дүгнэлт, ус ашиглах гэрээг усны тухай хуулийн дагуу зохих түвшний төрийн байгууллагаар гаргуулах	Үйл ажиллагааны зардал		Жил бүр	
	Адуунчулууны нүүрсний уурхайн ордын гидрогеологийн судалгааны ажлыг хийлгэх/мэргэжлийн байгууллагаар/	100 000.0/ нэг зуун сая/		2021	
	Ус ашигласны төлбөрийг тогтоосон хугацаанд төлж байх	Үйл ажиллагааны зардал		Жил бүр	

<p>Бохир ус хадгалах цооног, усны шугам гэмтэх, цоорох, халих зэргээс бохир ус хөрсөнд алдагдаж улмаар бага гүний уст үеийг бохирдуулж болзошгүй.</p>	<p>Бага оврын ус цэвэрлэх байгууламж суурилуулах. Ингэснээр бохир ус татан зайлуулах зардал байхгүй болж, дэвшилтэт технологи ашиглан усыг хоёрдогч хэрэглээнд ашиглах боломжтой болно. Бохир усны цооногийг ашиглах хугацааны туршид цооног болон усны шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг сайтар хангаж ажиллах, эвдрэл гэмтлийг нэн даруй засч сэлбэх</p>	<p>Үйл ажиллагааны зардал</p>	<p>2021-2025</p>
	<p>Жил бүр ундны усны эх үүсвэрээс дээж аван итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэх Төслийн талбай болон нөлөөллийн бүсэд байрлах малчдын гар худгийг сэргээн засварлах, худгуудын усны чанар, түвшний хэлбэлзлийг бүртгэх шинжилгээ хийлгэх</p>	<p>ОХШХ-т тусгагдсан.</p>	<p>Жил бүр</p>
<p>Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ</p>			

Уурхайн үйл ажиллагааны үлмаас газрын гадарга эвдрэх, газрын хэвлийд хоосон орон зай үүсэх	Хөрс хуулагт болон овоолгод өртөх талбайн үржил шимт хөрсийг тусад нь байршуулж нөхөн сэргээлтэд ашиглахад зориулан холбогдох стандартын дагуу хадгалах, тордох Уурхайн ашиглалтын талбайг үерийн уснаас хамгаалах далан байгуулах	Үйл ажиллагааны зардал	2021-2025 он	- MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. - MNS 5850:2006 Хөрсний чанар. Хөрс бохирдүүлэгч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.	
Олон салаа зам гарах, хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөс хөрс, ургамал талхлагдах, газар эвдрэлд орох	Олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж уурхайн дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	200.0	1.0	2021-2025	- MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага - MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт - MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага - MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага - Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 21.3 - БОНБУ тухай хууль - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх
Ахуйн хог хаягдлыг хөрсөн дээр шууд хаяснаар хөрс бохирдож болзошгүй.	Ахуйн хог хаягдлыг богино хугацаанд зайлуулж, хог хаягдлын болон бохирын цэгт тогтмол хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	300.0	1.5	Жил бүр	Жил бүр
	Хотхоны хогийн цэгийн суурийг хатуу хучилттай болгож, хог хаягдлаас үүсэх бохирдол хөрсөнд шууд нэвчихээс сэргийлэх	500.0	0.5	2021	Жил бүр
	Жил бүр хөрсний төлөв байдал ба бохирдлын шинжилгээ хийлгэж, шинжилгээний үр дүнд хяналт тавьж ажиллах	ОХШХ-т тусгагдсан.		Жил бүр	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага - MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага - Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 21.3 - БОНБУ тухай хууль - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх
Бохир ус хадгалах цооног, цоорох, халих зэргээс бохир ус хөрсөнд алдагдаж болзошгүй.	Бохир усны цооног болон усны шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг сайтар хангаж ажиллах, эвдрэл гэмтлийг нэн даруй засч сэлбэх			Тухай бүр	Тухай бүр
Химийн бодис, тос тосолгооны материалаас гарснаас хөрс бохирдох	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллах	100.0	1.0	Тухай бүр	Тухай бүр
	Засварын газрын суурийг хөрсөнд шууд хүрэлцэхгүй байхаар хатуу хучилттай болгох	500.0	0.5	2021	Тухай бүр

Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах	Хотхон орчмын сул талбайд өлөнгө, царгас зэрэг олон наст ургамал тарих	Нөхөн сэргээлтийн зардалд тусгав.			- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага - Амьтны тухай хууль
Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бүүснаар ургамал тоосонд дарагдаж ургалтанд нөлөөлж болзошгүй	Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	ОХШХ-т тусгагдсан.		Жил бүр	
Уул уурхайн үйл ажиллагаа, хүмүүсийн суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх	Амьтны аймгийн мониторинг судалгааг том хөхгөн амьтан, шувууд зэрэг чиглэлээр хийж хэрэгжүүлэх	ОХШХ-т тусгагдсан.		Жил бүр	
Уурхайн хөрс хуулалт, хашаа хаалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах	Хээрийн махчин, шувуудад зориулж хиймэл үүр хийж байрлуулах	100.0	0.5		
Хог хаягдал					
Хатуу хог хаягдлыг зөөж, тээвэрлэх	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулж байх улиралд 1 удаа	50.0	0.5	2021-2025	Хог хаягдлын тухай хууль 2017.05.12, Эрүүл ахуйн тухай хууль /2016.02.04/, болон БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт,
	Олон нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж уурхайн олборлолтын талбайн ойр орчимд үүссэн ил задгай хаягдсан хог хаягдлыг түүж тээвэрлэж байх	Жилд 2 удаа нийтийн цэвэрлэгээ хийх 50.0/маск. бээлий. хог цэвэрлэх хэрэгслүүд/	0.85	2021-2025	
	Дулааны улиралд хатуу болон шингэн хог хаягдлын цэгт хортон шавж үржих учраас ариутгал хийх	Жилд 2 удаа 140.0	0.7	2021-2025	
	Шингэн хог хаягдал цуглуулах байгууламж сууриллуулах, хаягдлыг тухай бүрт мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэн зайлуулах	Уурхайн сувчинд жилд 500.0	2.5	2021-2025	
Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ					

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хэрэгжилтийг хангах	Газрын төлөв байдлын үлсын чанарын хянан баталгааг тогтоосон хугацаанд хийлгэх	8.0	8.0	5 жил тутам 1 удаа	- БОНБУ тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 10 ¹
	Байгаль орчны аудитыг тогтоосон хугацаанд хийлгэх	5.0	5.0	2 жил тутам 1 удаа	- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
	Газар, үс ашигласны болон байгаль орчинтой холбогдолтой бусад төлбөрийг тогтоосон хугацаанд төлж байх	Үйл ажиллагааны зардал		Жил бүр	- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам-БОАЖС-ын 2014/126 тушаал
	Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг харгалзан ажиллах, иргэд болон орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах			Тухай бүр	- “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам” /1-р
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 5 жилийн нийт зардал – 132.71 сая.төг					

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардлыг 8 жилийн ашиглалтын үр дүнд үүсэх нөхцөл байдалд үндэслэн тооцоолсон бөгөөд уурхайг хааж нөхөн сэргээлт эхлэх хүртэл жил бүр хөрөнгө мөнгө төсөвлөн, хуримтлал үүсгэх нь нөхөн сэргээлтийг цаг тухайд нь эхэлж, үр дүнтэй явуулахад ач холбогдолтой юм. Тиймээс нөхөн сэргээлтийн ажлын зардлын хуримтлалыг үүсгэх дараах хуваарийг санал болгож байна.

Хүснэгт №128. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Шимт хөрсний овоолго үүсгэх	Овоолгын гадарга, хажууг хэлбэршүүлж олон наст ургамал тарих	Шимт хөрсийг уурхайн ухаш, овоолгын сууринд дарагдах нийт 20 га талбайгаас 0.2 м-ийн зузаантай хуулж хадгална.	324	5.2	2021 оноос ургамалжуулах ажлыг хийнэ.	- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Биологийн нөхөн сэргээлтийн туршилт болон орчны тохижилтыг сайжруулах	Улиас тарьж ургуулах	Жил бүр 2 га талбайд мод тарих	4.5	5.6*8га=45.0	Жил бүр	- MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Ажилчдын байр, барилгууд орчмын сул талбайг ургамалжуулах	Өлөнгө, царгас зэрэг олон наст ургамал тарих	Жил бүр 0.4 га-д	324	0.26*5=1.3	Жил бүр	- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн шаардлага

<p>Нөхөн сэргээлтийн ажлын хуримтлал үүсгэх</p>	<p>Борлуулалтын орлогоос хуримтлал үүсгэх</p>	<p>Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал, тухайн жилийн борлуулалтын орлогоос хамааруулан хуримтлуулах</p>	<p>Жил бүр</p>	<p>- “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” (БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаал)</p>
-------------------------------------------------	-----------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------	----------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний 5 жилийн зардал - 51.5 сая.төг

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэх талбайн хүрээнд болон төслийн хамгийн их нөлөөлөл бүхий бүсэд суурин айл өрхүүд байхгүй тул одоогоор ямар нэг нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын ажил төлөвлөгдөөгүй болно. Төсөл хэрэгжүүлэгч нь нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын талаар хуулийн хүрээнд судалж ажиллах хэрэгтэй.

Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн талбайгаас одоогийн байдлаар газар дээр болон газар доороос ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах талаарх Монгол Улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөнө.

Хүснэгт №128. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал/с төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Ажилчдын санаатай болон санамсаргүй үйлдэл, машин, техникийн эвдрэл гэмтэл, доголдлоос осол аваар гарах	Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах		Дотоод журмаар зохицуулах		Жил бүр	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5566:2005 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. MNS 4244:1994 Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага MNS 5150:2002 Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага
	Ажлын байранд эмнэлгийн анхны тусламж эмийн сантай байх	-	300.0	1.5		
	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах Ажилчдыг жил бүр эмнэлгийн үзлэгт хамруулах	Бүх ажилчид	Үйл ажиллагааны зардал			
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	тогтмол	Дотоод журмаар зохицуулах			
Шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад		500.0	2.5		
	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар болон аюулгүй ажиллагааны талаар, мөн байгалийн гамшгийн үед хэрхэх талаар ажилчдын дунд сургалт зохион байгуулах	Жилд 1 удаа	Дотоод журмаар зохицуулах		Жил бүр	

Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулна.	Тогтмол	Дотоод журмаар зохицуулах	Үйл ажиллагааны туршид
--------------------------------------------------------------------------------------	---------	---------------------------	------------------------

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал 4.0 сая төгрөг

Хүснэгт №129. Дүйцүүлэн хамгааллын нийт зардлын хэмжээ

Д/д	Зардлын нэр	Зардлын хэмжээ, сая.төг	Тайлбар
1	Е _г - Дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгааны зардал	1	Тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг ан амьтны тооллого г.м
2	Е _б -Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх зардал	2	ДХ-ыг төлөвлөхөд олон нийтийн оролцоог хангах, төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулах арга хэмжээний зардал
3	Е _о -Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал	13.067	“MDT – Mitigation Design Tool” загварчлалаар тооцоолсон дүн
4	Е _м -Гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардал	2.352	[(Е _г + Е _б + Е _о)*18%]
Нийт		19.419	Нэг жилийн зардал

Найнги ХХК-ийн 2021-2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжих дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний 1 жилийн зардал 19.419 сая.төг болно. Харин 5 жилийн нийт зардал 92.095 сая.төг байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОАЖЯ-д тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт №130. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах /2021-2025 он/

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцү үлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах эзэн
1.	Төрийн захиргааны төв байгууллага /БОАЖЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тайлагнах, батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч
2.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч
3.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч

БОМТ-ний зардлын хураангуй

Адуунчулууны нүүрсний ордыг ашиглах төслийн 2021-2025 оны хооронд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардлыг 291, 285,000.0 төг буюу гурван зуун хорин нэгэн сая хоёр зуун наян таван мянган төгрөг байхаар тооцоолов.

Хүснэгт №131. Адуунчулууны нүүрсний ордыг ашиглах төслийн 2021-2025 оны
БОМТ-ний нийт зардал

<i>Хэрэгжүүлэх арга хэмжээ</i>	<i>Зардал, төг</i>
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	132,710,000.00
Эхний 5 жилд хийгдэх нөхөн сэргээлт	51,500,000.00
Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	92,075,000.00
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4,000,000.00
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	11,000,000.00
<i>Нийт зардал</i>	<i>291,285,000.00</i>